

**МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨР,  
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН  
САЙДЫН ТУШААЛ**

2022 оны ... дугаар  
сарын ... -ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

**Журам өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.9 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А/65 тоот тушаалаар баталсан “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ, ахмад настанд үйлчилгээ үзүүлэх байгууллагыг магадлан итгэмжлэх журам”-ын 1.1, 2.3, 2.4, 6.1.2, 6.1.3, 6.1.4, 6.1.5, 7.2.1.2, 7.2.7 дахь хэсэгт доор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсугай.

“1.1 Энэхүү журмын зорилго нь Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.9, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 32.3 дахь хэсэгт заасны дагуу мөн хуулийн 18.1.1-18.1.6, 18.1.8, 18.1.10-д заасан Олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээ, Ахмад настны тухай хуулийн 7.1.2-7.1.4, 7.1-д заасан ахмад настанд үзүүлэх үйлчилгээ, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 32.2-т заасан үйлчилгээг үзүүлэх аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагад, Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.1.6, Ахмад настны тухай хуулийн 7.1.3-д заасан үйлчилгээг үзүүлэх иргэнийг тус тус магадлан итгэмжлэл олгох эсэх талаар шийдвэр гаргах, магадлан итгэмжлэх үйл ажиллагааг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2.3.Зөвлөлийн дарга нь Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын нийгмийн халамжийн асуудал хариуцсан газрын дарга байна;

2.4.Зөвлөлийн дарга, гишүүдийг нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын тушаалаар батална;

6.1.2. Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.1.1-18.1.6, 18.1.8, 18.1.10 -т заасан үйлчилгээ, Ахмад настны тухай хуулийн 7.1.2- 7.1.4, 7.1.9, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 32.2-т заасан үйлчилгээний төрлүүдээс үзүүлдэг байх;

6.1.3.Сэргээн засах үйлчилгээ үзүүлэхээр магадлан итгэмжлэл авах байгууллага нь хууль тогтоомжид заасан тохиолдолд эрх бүхий байгууллагаас эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сэргээн засах, уламжлалт эмчилгээний чиглэлээр авсан байх;

6.1.4. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ, ахмад настны үйлчилгээ үзүүлэх стандартын шаардлага хангасан, зориулалтын байртай байх;

6.1.5. Зөвшөөрөл, магадлан итгэмжлэлд заагдсан үйлчилгээг үзүүлэх мэргэжлийн боловсон хүчинтэй байх, хувийн туслах үйлчилгээ, зөвлөлдөх бүлэг буюу харилцан суралцах, зөвлөгөө өгөх үйлчилгээг үзүүлэх төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээнд тохирсон үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн болон туршлагатай хүний нөөцтэй байх;

7.2.1.2. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ болон ахмад настанд үзүүлэх үйлчилгээ, хувийн туслах үйлчилгээ, зөвлөлдөх бүлэг буюу харилцан суралцах, зөвлөгөө өгөх үйлчилгээний аль төрлийн үйлчилгээг үзүүлэх тухай;

7.2.7. Сүүлийн 2 жилийн хугацаанд Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ болон ахмад настанд үзүүлэх үйлчилгээ, хувийн туслах үйлчилгээ, зөвлөлдөх бүлэг буюу харилцан суралцах, зөвлөгөө өгөх үйлчилгээний ижил төстэй үйлчилгээний чиглэлээр ажиллаж байсан тохиолдолд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаарх тайлан мэдээлэл.”

ГАРЫН ҮСЭГ